

2024 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

2024 оны хурлын хэлэлцэх асуудал,  
ажлын төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А-1/279 дугаар удирдамж, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.28 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар 2024 онд хэлэлцэх асуудал, ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Отгонсүх/, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Гэрэлзул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОДХҮҮ

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар  
сарын 02-ний өдрийн 01... дугаар  
тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР  
2024 ОНД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал болон зохион байгуулах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж, ажилтан
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 2024 онд асуудал, ажлын төлөвлөгөө батлах тухай	2024 оны 02 сар	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б..Гэрэлзүл
2	Компанийн дунд болон урт хугацааны стратегийн баримт бичгийн төслийг хэлэлцэж батлах тухай	2024 оны 02 -03 сар	ЭЗХОГ-ын дарга Д.Банзрагч
3	Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитлагдсан санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргаж Хувьцаа эзэмшигчид мэдэгдэх тухай	2024 оны 03 сар	ЗУГ-ын дарга М.Алтан-Очир, Төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Болортуяа СНББХ-ийн дарга Г.Өлзийбаяр,
4	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай	2024 оны 03 сар	СНББХ-ийн дарга Г.Өлзийбаяр
5	Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх тухай /ТӨБЗГ-ын 184 дүгээр тогтоол/	2024 оны 03 сар	Гүйцэтгэх захирал Б.Отгонсүх ЗУГ-ын дарга М.Алтан-Очир
6	Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн төмөр замд мөрдөх шинэ тээврийн тариф болон тарифийн мөрдлөгийн тухай	2024 оны 03 сар	Тээвэр ложистик төлөвлөлтийн газрын дарга Г.Цолмонбаяр
7	Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах Бүс нутгийн логистикийн төвийн бүтэц үйл ажиллагаа, цаашид авч хэрэгжүүлэх ажлын тухай	2024 оны 04 сар	Тээвэр ложистик төлөвлөлтийн газрын дарга Г.Цолмонбаяр
8	Боомтын хил холболтын төмөр замын төслүүд, баруун, зүүн чиглэлийн төмөр замууд болон Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төслүүдийн явцын тухай	2024 оны 2-4 сар	Төслийн хэлтэс, Төслийн хэлтсийн дарга Т.Сайнжаргал
9	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан баруун болон зүүн чиглэлийн төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэхээр байгуулсан “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр	2024 оны 2-5 сар	Төслийн хэлтэс, Төслийн хэлтсийн дарга Т.Сайнжаргал

	зам” ХХК болон “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК-тай холбоотой асуудлын тухай		
10	Төмөр замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлын талаар хийсэн хяналт шалгалтын ажлын тайлангийн тухай	2024 оны 05 сар 2024 оны 10 сар	Хяналтын албаны дарга М.Эрдэнэсайхан
11	Компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлангийн тухай	2024 оны 06 сар 2024 оны 12 сар	Хяналтын алба, Дотоод аудитын мэргэжилтэн Ц.Батбаяр, Д.Уламбаяр
12	Өмчийн бүртгэл, ашиглалт, санхүүгийн үйл ажиллагааны явцын тухай	2024 оны 07 сар 2024 оны 12 сар	СНББХ-ийн дарга Г.Өлзийбаяр
13	Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тухай /хагас, бүтэн жил/	2024 оны 08 сар 2025 оны 03 сар	ЗУГ-ын дарга М.Алтан-Очир
14	Компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх тухай /шаардлагатай тохиолдолд/	2024 оны 8-9 сар	Төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Болортуяа, ІЗУАУГ-ын дарга Ц.Мэндбаяр
15	Компанийн 2023 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар өгсөн албан даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний биелэлтийн тухай	2024 оны 08 сар	СНББХ-ийн дарга Г.Өлзийбаяр
16	Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлах тухай	2024 оны 11-12 сар	Төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Болортуяа
17	Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж, батлах тухай	2024 оны 11-12 сар	Төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Болортуяа
18	Компанийн хэрэгжүүлж буй төслүүдтэй холбоотой шийдвэр гаргах, төлөвлөгөөнд тусгагдаагүй, цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудал, ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах бусад асуудал	Тухай бүр	Холбогдох газар, хэлтэс